

**"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК-ИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2024.05.20

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Үндэсний аудитын газраас "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийж, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах, цаашид гарсан алдаа дутагдлыг давтахгүй ажиллах, удирдлагыг холбогдох мэдээ, мэдээллээр хангах зорилгоор хяналт-шинжилгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам"-ыг үндэслэв.

Гурав. Танилцуулга

Үндэсний аудитын газраас "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланг 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 07/590 дугаартай албан бичгээр аудитын тайланг хүлээн авч, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу "Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө", төлөвлөгөөний биелэлтийг холбогдох баримт, материалын хамт хуулийн хугацаанд Үндэсний Аудитын газарт тус тус хүргүүлсэн.

"Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын албан шаардлага, залруулга, зөвлөмж, төлбөрийн акт, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх асуудлын хүрээнд 35 арга хэмжээнд хяналт хийж, хэрэгжилтэд 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар үнэлгээ хийхэд **98,7** хувьтай буюу **"Тодорхой үр дүнд хүрсэн"** гэсэн үнэлгээтэй байна.

Үүнд: Албан шаардлагын хүрээнд **100** хувьтай 7, **90** хувьтай 2, залруулгын хүрээнд **100** хувьтай 6, зөвлөмжийн хүрээнд **100** хувьтай 11, **90** хувьтай 3, **70** хувьтай 1 арга хэмжээ, төлбөрийн актын хүрээнд **100** хувьтай 3, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх асуудлын хүрээнд **100** хувьтай 2 арга хэмжээ байна. Эдгээр 35 ажлын хэрэгжилтийг доорх хүснэгтээр харуулав.

Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр:

/Нийт арга хэмжээний хүрээнд/

Хүснэгт 1.

№	Шийдвэрийн төрөл	Тоо	100%	90%	70%	50%	0%	Нийт %
1	Албан шаардлага	9	7	2	-	-	-	97,8
2	Залруулга	6	6	-	-	-	-	100
3	Зөвлөмж	15	11	3	1	-	-	96
4	Төлбөрийн акт	3	3	-	-	-	-	100
5	Хуулийн байгууллагад шилжүүлэх асуудал	2	2	-	-	-	-	100
Нийт арга хэмжээ		35	29	5	1	-	-	98,7